



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/59

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "а" заалт, Төсвийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Батчулуун-Засаг даргын орлогч  
Гишүүд: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга  
Ж.Чимэддулам-иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
нарийн бичгийн дарга  
Д.Бадамдулам-Санхүүгийн албаны дарга  
Б.Янжиндулам-Байгаль орчны хяналтын улсын байцаагч  
Г.Цэрэндулам- Нийгмийн бодлогын мэргэжилтэн  
С.Ганхүлэг-Газрын даамал  
Э.Буянтогтох-Хөдөө аж ахуй тасгийн мэргэжилтэн  
Г.Бямбагарав-Иргэний төлөөлөл

2. Багуудаас гарсан саналыг журмын дагуу боловсруулж, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дарааллаар нь нэгтгэн боловсруулж, зөвлөмж, дүгнэлтийг гарган ирүүлэхийг ажлын хэсэг (Л.Батчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА М.ЖАМЪЯНШАРАВ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051010117